



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар А/198

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Донорын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Донороос эс, эд, эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах журмыг нэгдүгээр, Эс, эд, эрхтэнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг хамтран зохион байгуулах эрүүл мэндийн байгууллагатай хийх гэрээний загварыг хоёрдугаар, Амьд донорын зөвшөөрлийн хуудсыг гуравдугаар, Тархины үхлийн шинжлэх, бүртгэх маягыг дөрөвдүгээр, Амьгүй донорын гэр бүлийн гишүүний зөвшөөрлийн хуудсыг тавдугаар, Тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн авсан тухай тэмдэглэл хөтлөх маягыг зургаадугаар, Реципиентийн зөвшөөрлийн хуудсыг долоодугаар, Амьгүй донорын тодорхойлолтыг маягыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга/захирал нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/504 болон 2019 оны А/164 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С. ЧИНЗОРИГ